



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

189 /189/

2021.11.29

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ОХУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ



Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, БХЗГ-ын дарга, хурандаа Б.Түвшинтөр, ЗХЖШ-ын Материал, техникийн хангалтын газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр тэргүүтэй албаныхан энэ сарын 22-25-ны өдрүүдэд ОХУ-ын Санкт-Петербург хотноо зохион байгуулагдсан Монгол, Оросын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хамтарсан ажлын хэсгийн XII хуралдаанд оролцлоо. Хамтарсан хуралдааны хүрээнд төлөөлөгчид ОХУ-ын Батлан хамгаалах аж үйлдвэрийн зарим байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан юм. Тодруулбал, Санкт-Петербург хотноо байрладаг Батлан хамгаалах аж үйлдвэрийн "СТЦ" ХХН-д зочилж, тус нийгэмлэгийн үйлдвэрлэсэн "Орлан" нисгэгчгүй нисэх хэрэгслийг

үзэж сонирхлоо. Уг нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь 5000 хүртэлх метрийн өндөрт 150 км/цагийн хурдтайгаар 1000 км замыг туулах чадвартай гэдгийг тус нийгэмлэгийн мэргэжилтнүүд онцолжээ. "Орлан" нисгэгчгүй нисдэг хэрэгслийг ОХУ-ын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг зэрэг бусад хүчний байгууллагууд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд гадны зарим улс орнуудад захиалгаар нийлүүлдэг байна. Түүнчлэн 1941 оноос эхлэн төрөл бүрийн хуягт техникийг үйлдвэрлэж буй "61 БТРЗ" ХН-ийн үйл ажиллагаатай нь танилцсан байна. Тус үйлдвэрийн ерөнхий захирал Р.В.Чепурнов өөрийн байгууллагын түүх, үйл ажиллагааны чиглэл, цаашид Монгол Улстай хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ.



НҮБ-ЫН ШТАБЫН ОФИЦЕРЫН ДАМЖАА ЯВАГДАЖ БАЙНА



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Дэлхийн энхийг санаачлагч байгууллага хамтран жил бүр зохион байгуулдаг НҮБ-ын цэргийн штабын офицерын дамжааг энэ удаа Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв бие даан Англи хэл дээр НҮБ-ын сургалтын стандарт хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулж байна. 2009 оноос эхлэн АНУ-ын Дэлхийн энхийн ажиллагааны санаачлагч байгууллагатай хамтран зохион байгуулдаг дамжаануудыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг

дэмжих ажиллагааны сургалтын төв бие даан зохион байгуулж байгаа нь Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл явуулах багш, сургагч нарын чадавх хэрхэн өссөнийг харуулж байна. Дээрх дамжаанд Зэвсэгт хүчний 15 анги, байгууллагын 19 цэргийн алба хаагч хамрагдаж байгаа бөгөөд сургалт хоёр долоо хоногийн хугацаанд үргэлжлэх юм. Уг сургалтын зорилго нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд штабын ажилтнаар үүрэг гүйцэтгэхэд тухайн ажиллагааны мандат болон бусад

эрх зүйн баримт бичиг, шийдвэрээр хүлээсэн үүргээ мадаггүй биелүүлэх мэдлэг, чадвар, дадлага олгоход чиглэгдэж байна. Мөн сургалтаар энхийг сахиулах ажиллагаанд үүргээ гүйцэтгээд ирсэн зарим офицерууд, Монголын Улаан Загалмайн хороо, Цагдаагийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний анги, байгууллагын офицеруудыг зочин багшаар урин хичээл заалгаж сургалтыг үр дүнтэй явуулах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв нь АНУ-ын Дэлхийн энхийн ажиллагааны

санаачлаг байгууллагатай хамтран 2012 оноос эхлэн НҮБ-ын штабын офицерын дамжааг 5 удаа зохион байгуулсан бөгөөд гадаадын долоон орны 34, Зэвсэгт хүчний анги, байгууллагын 94 офицер, ахлагч суралцан төгсөж энхийг сахиулах ажиллагааны хүчний болон секторын штабт үүргээ амжилттай гүйцэтгэсэн байна. Ташрамд хэлэхэд өнөөдрийн байдлаар Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штаб болон энхийг сахиулах ажиллагаанд 18 офицер, ахлагч үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

Түүхэнд энэ өдөр

1911 он. Энэ сарын эцэст Халхын

Хүрээний бүх хэргийг ерөнхийлөн шийтгэж

газраас цэрэг татлага явуулах шийдвэр

гаргав.

1934 он. ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн

жанжны 63 тоот тушаалаар Цэргийн яамны

дэргэд зөвлөхийн албан тушаалыг бий

болгож, Я.В.Шеког томилжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-25

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.29 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 25/

ТУГЧИН ОДТОЙ, ХАР МОРЬ ӨДӨР.

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.19-17.02

Барилдлага:

Хучин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Хүрэлцэхүй

Суудал:

Шороо

Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, гарагийг тахих, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
370.197 +509

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,875 +7

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6476 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
127

ЭДГЭРСЭН
6275

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 258,988,844

Эдгэрсэн

Нийт: 234,298,264

Нас барсан

Нийт: 5,182,246

цахим шууданд


ЦЭРГИЙН АЛБАНААС БЭЛТГЭЛЭЭР ХАЛАГДСАН ОФИЦЕРУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Тус анги нь 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Бүгд Найрамдах Улс тунхагласны 97 жилийн ойн баярыг тохиолдуулан энэ онд цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан офицер, ахлагч нар ангийн Байлдааны туганд хүндэтгэл үзүүлээ. Мөн 11 дүгээр сарын цэргийн алба сахилгын дүн гаргаж, цэргийн тангараг давтах арга хэмжээг зохион байгуулав. Энэ үеэр ангийн захирагч, хурандаа Ш.Аюурзана өнгөрсөн сард Зэвсэгт хүчинд болон АЦК, ангид хийгдсэн онцлох ажлуудыг товч дурдан ирэх сард хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулсан юм. Мөн зарим цэргийн алба хаагчид, ажилчин албан хаагчдад Батлан хамгаалах салбарын шагнал, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, бусад шагналыг гардуулав.

"ЭНХИЙГ САХИУЛАГЧ" ШҮЛГИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтан энхийг сахиулах ажиллагааны түүх, ач холбогдол, оролцоог түгээн дэлгэрүүлэх, энхийг сахиулагчдын сүр хүчийг сурталчлах зорилгоор нэгтгэлийн нийт бие бүрэлдэхүүний дунд "Энхийг сахиулагч" сэдэвт шүлгийн уралдааныг зохион байгууллаа. Тэмцээнд нийт 20 гаруй алба хаагч оролцсоноос дэд ахлагч Ж.Цэнгүүнбаяр тэргүүн байрт шалгарав. хошууч Д.ДОЛГОРЖАВ

"БОЛЖМОРЫН ЖИРГЭЭ" БАГ ТЭРГҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Баяр, амралтын өдрийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу хугацаат цэргийн алба хаагчдад аймаг, орон нутгийг сурталчлах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумын хөшөөт цогцолбор /Батмөнх даян хааны хөшөө, Ажнай талбай, ГАЗ-67 машины хөшөө, Гурван хатны хөшөө, Монгол улсын баатар Т.Борын хөшөө, Улсын хурц арслан Г.Дэмүүлийн хөшөө/ бүтээн байгуулалттай танилцууллаа.



Мөн Улс тунхагласны 97 жилийн ойн баярын өдөрт зориулсан хүчит бөхийн барилдааныг өргөн дэлгэцээр үзүүлж, "Эх орны сэдэвт дууг хэн сайн дуулах вэ?"

караоке тэмцээнийг гурван үе шаттайгаар зохион байгуулав. Тус тэмцээнд зургаан салааны 35 байлдагч оролцсоноос Минометын батареины "Болжморын жиргээ" баг

25 оноогоор тэргүүн байр эзэлж, Танкны салааны "Т-72" баг 22 оноогоор дэд байрт шалгарлаа.

Дэслэгч Г.НАНДИНЧИМЭГ

ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛ



нөхцөлд амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр бие бүрэлдэхүүний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хордсон газар орныг туулах, байр зүйн баримжаалал хийх, гэнэтийн отолт, халдлагын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шархадсан хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, татан гаргалтыг хийх зэрэг даалгаврыг гүйцэтгэв. Мөн зам дундах тактикийн ажиллагаа болон алба тасгуудын дунд зохион байгуулсан соёл хүмүүжлийн ажлын хүрээнд "Олс таталт"-ын тэмцээнийг явуулсан бөгөөд ахлах ахлагч Д.Шижиртөгс ахлагчтай "Бид хүчтэй" багийн тамирчид тэргүүн байр эзэллээ.

Зэвсэгт хүчний 314 дүгээр анги

Ангийн 2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн

төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сарын 24-ний өдөр 30 км-ийн явган маршийг цаг агаарын хүндрүүлсэн



ШАГАЙН ХАРВААНЫ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Юнескогийн хүн төрөлхтний соёлын өвд бүртгэгдсэн Монгол үндэсний уламжлалт спорт тоглоом шагайн харвааг сурталчлан таниулах, залуу хойч

үеийнхэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх, үндэсний өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, харваачдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор үндэсний шагай харвааны тэмцээнийг Цэргийн штаб, Өмнөговь аймгийн шагайн харвааны салбар холбоо, Таван толгой ХК-тай хамтран өнгөрөгч амралтын

өдрүүдэд зохион байгуулав. Уг тэмцээнд МУ-ын Үлэмж дархан мэргэн 4, МУ-ын Гарамгай мэргэн 2, МУ-ын Хошой мэргэн 4, МУ-ын мэргэн 2, МУ-ын харьшгүй мэргэн 1, МУ-ын хүндэт харваач 16, аймгийн мэргэн 27 харваач, нийт 24 багийн 200 гаруй тамирчин оролцож онч мэргэнээ сорьсноос багийн төрөлд Ханхонгор сумын Б.Түвшинбаяр, Ханбогд сумын С.Ууганбаяр, Таван толгой ХК-ны Доржсүрэн ахлагчтай багууд тэргүүлсэн бол хувийн цуваа харвааны төрөлд Цогтцэций сумын харваач Б.Эрдэнэ, Ханхонгор сумын харваач П.Бямбаатогтох, Ж.Баасанхүү нар тэргүүлж өргөмжлөл, медаль, мөнгөн шагналын эзэд болов.

Дэд хурандаа Б.БЭРХГАЛТ

БУЙЛС ЦЭЦЭГЛЭХ ЦАГААР НЭЭЛТЭЭ ХИЙНЭ

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар анги 1932 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан бөгөөд 1934 онд жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит болсон түүхтэй. Тус анги 2022 онд 90 жилийн ойтойгоо золгох гэж байна. Түүхэн ойг угтаж "Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн"-г байгуулах ажлыг эхлүүлсэн билээ. Бид энэхүү цэцэрлэгт хүрээлэнд хайлаас мод 400 ширхэг, буйлс модны 1000 ширхэг үрийг суулгаад байгаа бөгөөд цэцэрлэгт хүрээлэнд жанжин Д.Сүхбаатарын хөшөө, VI морьт дивизийн дурсгалын цогцолбор, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах



талбай зэргийг байгуулах юм. Энэхүү цэцэрлэгт хүрээлэнгийн нээлтийг буйлс цэцэглэх цагаар хийх юм. Дорноговь аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цөлжилт, шар шороон шургаас сэргийлэх, ажиллах орчноо сайжруулах, ирээдүй хойч үедээ эрүүл, аюулгүй орчныг өвлүүлэн үлдээх зорилгоор бүтээгдэж буй тус цэцэрлэгт хүрээлэн

Дорноговь аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дунд явагдсан "Ногоон Дорноговь" мод тарих уралдаанд тэргүүн байрт шалгарч ангийн захирагч, хурандаа А.Болдбаатар 2021 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нараас "Батламж"-аа гардан авлаа.

Ахлах дэслэгч А.АЛТАНХУЯГ

ЗААХ АРГЫН ЦУГЛАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Ангийн 2020-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу ангийн удирдлага, хорооны төвийн офицерууд, харьяа Тусгай ротуудын захирагч нарын заах арга зүйн цугларалтыг "Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөлт-байлдааны бэлэн байдал" сэдвээр явууллаа. Уг цугларалтад тусгай салбарын нууцны дарга, холбооны салааны захирагч, ротын ахлагч нарыг мэргэжлийн ур чадварын бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор оролцуулсан юм. Цугларалтыг гурван үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд "Цэргийн сургалт бэлтгэлийн орчны шинэчлэл" сэдвийн хүрээнд ангийн захирагч, хурандаа Г.Чулуунзагд "Анги байгууллагын хөгжил, цэргийн алба, бие бүрэлдэхүүний төлөвшил", Захирагчийн орлогч-захираганы удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа П.Мэндбаяр "Байгууллагын соёл", ССХА-ны

дарга, хошууч Э.Болор-Эрдэнэ "Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах, онцлог, арга зам", Командын байрын дарга, дэд хурандаа Т.Армия "Байлдааны жижүүрлэлтийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах онцлог" сэдвүүдээр тус тус сургалт явуулав. Дараагийн шат буюу "Байлдааны бэлэн байдлын төлөвлөлт" сэдвийн хүрээнд ангийн захирагч, хурандаа Г.Чулуунзагд "Монгол Улсын аюулгүй байдлын орчин, Цэрэг-Улс төр стратегийн нөхцөл байдал", Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Д.Хишигбаатар "Байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалт явуулах, зохион байгуулах онцлог", Ажиллагааны удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа Д.Батдаваа

"Мотобуудлагын салааны хориглолт" сэдвээр хорооны төвийн дунд офицерууд болон цугларалтад хамрагдаж буй салбарын бүрэлдэхүүнтэй "Тактик жагсаалын хичээл"-ийг, Зэвсгийн офицер, ахмад Б.Амартүвшин "Зенитийн суурьт пулемёттоор буудлага хийх үед гарч болзошгүй гацаа, саатал, тэдгээрийг арилгах" сэдвээр тус тус сургалт явуулав. Гуравдугаар шатанд командын байрын дарга, дэд хурандаа Т.Армия "Бүрэн тоотын дадлага" байлдааны жижүүрлэлтийн хэлэлцүүлэг явуулсан юм. Мөн салбарын захирагч нар 2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн болон байлдааны бэлэн байдал, хангалтын төлөвлөгөө батлуулав. Цугларалтын төгсгөлд салбаруудын 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэж, хошуучилсан салбаруудын шагнаж урамшууллаа. Энэ онд хийж бүтээсэн ажлын үзүүлэлтээрээ нэгдүгээр байрт хошууч Б.Мөнхзул захирагчтай 116 дугаар тусгай рот, хоёрдугаар байрт ахмад М.Баянбилэг захирагчтай 274 дүгээр рот, гуравдугаар байрт хошууч Х.Аскербек захирагчтай 103 дугаар рот тус тус шалгарсан юм. Түүнчлэн цугларалтад оролцож буй бүрэлдэхүүний дунд эхний дөр "Гар бөмбөг"-ийн тэмцээн, хоёр дахь өдөр нь соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулав.